

ШУУД ШИЛЖҮҮЛСЭН БИЧИГ

Бүртгэлд авсан	
огноо	хүн
2014.01.17	Болорцэцэг

Бүртгэлийн №: 292

Бичгийн		
огноо	дугаар	хуудас
2014.01.17	01/222	3.0

Аймаг, хот: Улаанбаатар

Байгууллагын ялгаа: Агентлаг, яам, газар

Хаанаас: Гаалийн Ерөнхий газар

Хэнээс: О.Ганбат

Хэнд: Энхболд.З

Ялгаа: Албан тоот

Утга: Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааны талаар

Удирдлагын
заалт:

ЭЗБХ

Мажидзав.
Ганц 2014.01.17

Татваргүй


2014.01.27

Шилжүүлсэн газар, алба: Улсын Их Хурлын Дарга

Хэнд шилжүүлсэн: Энхбаяр.Ж

Хэзээ шилжүүлсэн: 2014.01.17

Гарын үсэг: _____





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их тойруу 81/1, Утас: 35-00-54, Факс: (976-11) 35-00-60,
E-mail: gaali@customs.pmis.gov.mn,
<http://www.customs.pmis.gov.mn>

2014. 01. 17 № 01/222

танай _____-ны № _____-т

Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааны талаар

“Гаалийн тухай хууль”-ийн дагуу Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтан, Монгол Улсын гаалийн хилээр нэвтрэх зорчигчид олон улсын стандартад нийцсэн бараа бүтээгдэхүүнээр үйлчлэх учиртай татваргүй барааны дэлгүүрүүд ажилладаг. Өнөөдөр Улаанбаатар хотын төвд 5, Чингис хаан Олон улсын нисэх буудалд 9, Замын-Үүдэд 2, Алтанбулагт 2, Гашуунсухайтад 1, Шивээхүрэнд 1, нийт 20 дэлгүүр ажиллаж байна. Тэд бүгд архи, тамхи, дотоодын үйлдвэрийн ноолууран бүтээгдэхүүн голлон борлуулдаг бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан учраас тэдгээрийн үйл ажиллагаанд нь Гаалийн ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрууд хамтарсан шалгалт хийсэн юм.

Шалгалтаар татваргүй барааны дэлгүүрүүд хууль тогтоомж, журмын заалтуудыг огт мөрддөггүй, телекамерийн систем нь гаалийн хяналтын шаардлагыг хангаагүй, гаалийн байгууллагад худал мэдээ өгдөг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийлүүлэлтийн сүлжээнээс бусад эргэлзээтэй эх үүсвэрээс /”Престиж суплайз инк” ХХК/ бараа татдаг зэрэг ноцтой зөрчил гаргаж байгаа нь илэрлээ.

Зөвхөн 2013 онд монголын аж ахуйн нэгжүүд нийт 423 мянган литр архи, согтууруулах ундаа /цагаан архи, коньяк, виски, ром, бренди, тикилла, ликёр, джин/ импортлосон байхад татваргүй барааны дэлгүүрүүд 441 мянган литрийг гаалийн хяналтын бүсэд оруулсан нь 4.3 хувиар их байна. Татваргүй барааны дэлгүүрт оруулсан архины дийлэнхийг Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт оруулсан байж болзошгүй юм.


Нягтлан шалгахад гаалийн хяналт, шалгалт суларч, ор нэр төдий хэрэг болж хувирснаас үйлчилгээний хүрээний бус хүмүүст үйлчлэх, нэг хүнд худалдаалах зөвшөөрөгдсөн хэмжээг ихээр хэтрүүлэн борлуулах, хэт ойрхон давтамжтайгаар нэг хүний нэр дээр зарагдаж байжээ.

Үүнээс гадна ялангуяа “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь дэлгүүрүүдэд оногдож буй талбайн хэмжээ хэт бага /50,0 кв. м/ байгаа нь олон улсын стандартын шаардлагад нийцэхгүй юм.

Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөл 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа шалгалтын дүнг хэлэлцээд татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдалд бодит занал учруулах хэмжээнд хүрсэн байна гэж үзээд, тэдгээрийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгалгүй татан буулгахаар шийдвэрлэсэн болно.

Бид энэ оны эхний хагаст багтаан ийм төрлийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлж, гаалийн хяналт, шалгалтын технологи, арга ажиллагаа, татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх зорилтыг дэвшүүлээд байгаагаа үүгээр уламжилж байна.

ДАРГА



О. ГАНБАТ

2012-2013 оны 2208 кодтой соггууруулах ундааны мэдээ

2013 он- хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр

	Горимын код	2012.12.31		2013.12.31 (ХБГ)		Нийт тоо хэмжээ, /2012-2013/ мян.литр	Нийт үнийн дүн /2012-2013/, сая.ам.доллар
		Тоо хэмжээ, мян.литр	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо хэмжээ, мян.литр	Үнийн дүн, сая.ам.доллар		
Гадаад худалдааны барааны статистик	400	11.9	0.1	17.5	0.1	29.4	0.1
	700	531.1	7.3	405.4	5.7	936.5	13.0
	Дүн	543.0	7.4	422.9	5.7	965.9	13.1
Татвартай импорт /400,451,456/	400	11.9	0.1	17.5	0.1	29.4	0.1
	451	281.6	3.7	366.9	5.3	648.5	8.9
	456	0.032	0.001	-	-	0.032	0.001
Дүн	293.5	3.7	384.4	5.3	677.9	9.0	
Татваргүй барааны дэлгүүрт /740,742/	740	384.4	4.6	322.1	4.0	706.5	8.5
	742	103.6	1.2	119.1	1.4	222.7	2.6
	Дүн	488.0	5.8	441.3	5.3	929.3	11.1

Тайлбар: 400 Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах

451 Гаалийн баталгаат агуулахаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах

456 Татваргүй барааны дэлгүүрээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах

700 Хилийн чанадаас гаалийн баталгаат агуулахад оруулах

740 Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулах

742 Гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах